



МОНГОЛЫН  
ХӨРӨНГИЙН  
БИРЖ

2020

*Э-сонин*

8-Р САР

85-р дугаар






## Зах зээлийн тойм


/2020.08.31-ний өдрийн байдлаар/

|                                            |                  |
|--------------------------------------------|------------------|
| 1. Арилжаа явагдсан өдөр                   | 21               |
| 2. Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/       | 5,135,127,956.29 |
| Хувьцаа /анхдагч/                          | 0                |
| Хувьцаа /хоёрдогч/                         | 5,090,536,576.29 |
| Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/        | 0                |
| Компанийн бонд /анхдагч/                   | 0                |
| Компанийн бонд /хоёрдогч/                  | 44,591,380       |
| 3. Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг | 23,550,729       |
| Хувьцаа /анхдагч/                          | 0                |
| Хувьцаа /хоёрдогч/                         | 23,550,283       |
| Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/        | 0                |
| Компанийн бонд /анхдагч/                   | 0                |
| Компанийн бонд /хоёрдогч/                  | 446              |
| 4. Нийт хийгдсэн хэлцлийн тоо              | 4,655            |


## Зах зээлийн үнэлгээ




## TOP-20 индекс



## MSE A индекс



## MSE B индекс



## Бүртгэлтэй хувьцаат компани

|                          |     |
|--------------------------|-----|
| 1. Нийт компанийн тоо    | 199 |
| 100% төрийн өмчит        | 18  |
| Төрийн өмчийн оролцоотой | 10  |
| Хувийн өмчийн            | 171 |
| I ангилал                | 14  |
| II ангилал               | 44  |
| III ангилал              | 140 |

## Гишүүн үнэт цаасны компани

|                                     |    |
|-------------------------------------|----|
| 1. Гишүүн Үнэт цаасны компанийн тоо | 54 |
| Үүнээс: Брокер, Дилер               | 54 |
| Андеррайтер                         | 19 |
| Хөрөнгө оруулалтын зөвлөх           | 14 |



## Арилжаанд идэвхтэй оролцсон гишүүн үнэт цаасны компаниуд

/2020.08.31-ний байдлаар/

|    | Нэр                              | Үнэт цаас авсан |                 | Үнэт цаас зарсан |                 | Арилжааны дүн / авсан, зарсан/ (төг) |
|----|----------------------------------|-----------------|-----------------|------------------|-----------------|--------------------------------------|
|    |                                  | Тоо ширхэг      | Үнийн дүн (төг) | Тоо ширхэг       | Үнийн дүн (төг) |                                      |
| 1  | Инвескор капитал ҮЦК             | 1,200,311       | 2,709,866,188   | 1,203,925        | 2,718,991,314   | 5,429,057,502                        |
| 2  | БиДиСек ХК                       | 12,640,199      | 1,332,133,637   | 12,408,545       | 1,309,129,394   | 2,641,263,031                        |
| 3  | Мирэ Эссет Секьюритис Монгол ХХК | 3,748,707       | 122,554,712     | 3,582,155        | 125,273,452     | 273,419,704                          |
| 4  | Ард секьюритиз ХХК               | 425,463         | 122,426,812     | 498,778          | 150,461,453     | 272,888,265                          |
| 5  | Гаули ХХК                        | 670,032         | 166,765,213     | 371,708          | 59,217,519      | 225,982,732                          |
| 6  | Стандарт инвестмент ХХК          | 531,943         | 112,265,041     | 586,337          | 93,825,639      | 206,090,680                          |
| 7  | Апекс Капитал ҮЦК                | 1,294,101       | 81,202,967      | 650,354          | 122,771,022     | 203,973,989                          |
| 8  | Бумбат-Алтай ХХК                 | 944,160         | 107,602,352     | 886,740          | 88,173,953      | 195,776,305                          |
| 9  | Ти Ди Би Капитал ХХК             | 541,118         | 97,573,437      | 225,655          | 61,390,145      | 158,963,581                          |
| 10 | Ард капитал групп ХХК            | 95,275          | 18,255,481      | 72,278           | 44,941,213      | 111,396,693                          |
| 11 | Новел инвестмент ХХК             | 53,765          | 55,953,988      | 312,692          | 37,259,668      | 93,213,656                           |
| 12 | Голомт Капитал ХХК               | 229,019         | 47,816,579      | 209,943          | 34,809,262      | 82,625,841                           |
| 13 | Райнос инвестмент ҮЦК ХХК        | 0               | 0               | 1,644,395        | 51,555,089      | 66,248,309                           |
| 14 | Эм Ай Би Жи ХХК                  | 0               | 0               | 140,469          | 45,453,289      | 45,453,289                           |
| 15 | Лайфтайм инвестмент ХХК          | 3,723           | 19,716,930      | 20,606           | 9,488,714       | 29,205,644                           |
| 16 | Зэргэд ХХК                       | 100,799         | 24,334,142      | 157,186          | 3,971,154       | 28,305,296                           |
| 17 | Монсек ХХК                       | 234,745         | 16,560,660      | 61,115           | 9,899,562       | 26,460,222                           |
| 18 | Гүүдсек ХХК                      | 39,335          | 14,468,167      | 23,778           | 10,409,894      | 25,278,061                           |
| 19 | Санар ХХК                        | 28,415          | 2,934,000       | 57,000           | 16,322,345      | 19,256,345                           |
| 20 | Централ секьюритиз ҮЦК           | 46,864          | 6,338,442       | 80,916           | 12,206,176      | 18,642,617                           |

## Идэвхтэй арилжигдсан хувьцаа

/2020.08.31-ний байдлаар/

| №  | Симбол | Үнэт цаасны нэр                         | Арилжигдсан ширхэг | Үнийн дүн (төг) | Дээд Ханш | Доод Ханш | Өөрчлөлт /%/ |
|----|--------|-----------------------------------------|--------------------|-----------------|-----------|-----------|--------------|
| 1  | INV    | ИНВЕСКОР ББСБ                           | 1,209,694          | 2,734,137,096   | 2,849     | 2,535     | 4.73         |
| 2  | JTB    | ЖЕНКО ТУР БЮРО                          | 11,495,909         | 1,091,905,911   | 89        | 76        | -4.49        |
| 3  | APU    | АПУ                                     | 504,740            | 292,186,932     | 610       | 543       | 0.59         |
| 4  | ERDN   | ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН ХК | 197,937            | 189,308,791     | 1,065     | 807       | -2.01        |
| 5  | LEND   | ЛЭНДМН ББСБ ХК                          | 5,450,703          | 171,515,491     | 36        | 30        | -3.05        |
| 6  | GOV    | ГОВЬ                                    | 700,831            | 137,858,812     | 206       | 182       | 5.23         |
| 7  | AARD   | АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ                   | 61,185             | 67,512,354      | 1,250     | 1,002     | -17.68       |
| 8  | MNDL   | МАНДАЛ ДААТГАЛ                          | 1,538,184          | 65,198,613      | 45        | 40        | 10.23        |
| 9  | TTL    | ТАВАН ТОЛГОЙ                            | 10,570             | 59,076,210      | 6,150     | 5,350     | 4.80         |
| 10 | BODI   | БОДЬ ДААТГАЛ                            | 424,367            | 49,229,352      | 125       | 108       | 4.65         |
| 11 | AIC    | АРД ДААТГАЛ ХК                          | 61,309             | 44,569,454      | 741       | 660       | 2.82         |
| 12 | UID    | УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР                        | 35,366             | 42,079,983      | 1,500     | 880       | 64.77        |
| 13 | TUM    | ТҮМЭН ШУВУУТ                            | 222,546            | 33,930,471      | 176       | 143       | 7.57         |
| 14 | SUU    | СҮҮ                                     | 134,314            | 26,799,957      | 207       | 190       | -3.66        |
| 15 | NEH    | ДАРХАН НЭХИЙ                            | 901,484            | 13,762,714      | 16        | 13        | 26.61        |
| 16 | MFC    | МОНОС ХҮНС                              | 173,891            | 10,734,454      | 64        | 60        | -0.06        |
| 17 | BNG    | БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ                    | 326                | 8,876,900       | 33,000    | 24,000    | -9.68        |
| 18 | ADB    | АРД КРЕДИТ ББСБ ХК                      | 107,174            | 6,906,683       | 69        | 62        | -2.96        |
| 19 | SHG    | ШАРЫН ГОЛ                               | 6,139              | 5,156,072       | 840       | 820       | -5.05        |
| 20 | MBW    | МОНГОЛ БАЗАЛЫТ ХК                       | 22,668             | 4,395,383       | 199       | 188       | 0.79         |



## Ханшийн өсөлттэй хувьцаа

/2020.08.31-ний байдлаар/

| №  | Үнэт цаас нэр                 | Арилжигдсан<br>/Ширхэг/ | Хаалтын ханш (төг) |            | Ханшийн<br>өөрчлөлт (төг) | Өөрчлөлт %/ |
|----|-------------------------------|-------------------------|--------------------|------------|---------------------------|-------------|
|    |                               |                         | 2020-08-01         | 2020-08-31 |                           |             |
| 1  | УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР              | 35,366                  | 880.00             | 1,450.00   | 570.00                    | 64.77       |
| 2  | ДАРХАН НЭХИЙ                  | 901,484                 | 11.50              | 14.56      | 3.06                      | 26.61       |
| 3  | СТАНДАРТ АГРИКАЛЧЕР ГРУПП     | 2,563                   | 55.00              | 68.00      | 13.00                     | 23.64       |
| 4  | ТАЛХ ЧИХЭР                    | 280                     | 12,430.00          | 14,990.00  | 2,560.00                  | 20.60       |
| 5  | ТЭЭВЭР-АЧЛАЛ                  | 25                      | 920.00             | 1,058.00   | 138.00                    | 15.00       |
| 6  | ТЭЭВЭР ДАРХАН                 | 1                       | 6,500.00           | 7,475.00   | 975.00                    | 15.00       |
| 7  | БАЯНТАЛБАЙ                    | 2                       | 74.75              | 85.96      | 11.21                     | 15.00       |
| 8  | МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО     | 517                     | 376.00             | 429.90     | 53.90                     | 14.34       |
| 9  | ХАЙ БИ ОЙЛ                    | 550                     | 56.00              | 64.00      | 8.00                      | 14.29       |
| 10 | ХИШИГ УУЛ                     | 10                      | 602.00             | 682.00     | 80.00                     | 13.29       |
| 11 | МАНДАЛ ДААТГАЛ                | 1,538,184               | 40.17              | 44.28      | 4.11                      | 10.23       |
| 12 | УБ-БҮК                        | 8,689                   | 404.00             | 445.00     | 41.00                     | 10.15       |
| 13 | ГЕРМЕС ЦЕНТР                  | 6,526                   | 130.00             | 140.00     | 10.00                     | 7.69        |
| 14 | ТҮМЭН ШУВУУТ                  | 222,546                 | 154.64             | 166.34     | 11.70                     | 7.57        |
| 15 | МОНГОЛ ШЕВРО                  | 77                      | 1,590.00           | 1,700.00   | 110.00                    | 6.92        |
| 16 | НОЁТ ХАЙРХАН                  | 4                       | 340.00             | 363.00     | 23.00                     | 6.76        |
| 17 | ГОНИР                         | 19                      | 750.00             | 800.00     | 50.00                     | 6.67        |
| 18 | НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ | 14,135                  | 85.00              | 90.00      | 5.00                      | 5.88        |
| 19 | БАГАНУУР                      | 3,983                   | 852.20             | 900.00     | 47.80                     | 5.61        |
| 20 | ГОВЬ                          | 700,831                 | 187.97             | 197.80     | 9.83                      | 5.23        |

## Ханшийн бууралттай хувьцаа

/2020.08.31-ний байдлаар/

| №  | Үнэт цаас нэр         | Арилжигдсан<br>/Ширхэг/ | Хаалтын ханш (төг) |            | Ханшийн<br>өөрчлөлт (төг) | Өөрчлөлт % |
|----|-----------------------|-------------------------|--------------------|------------|---------------------------|------------|
|    |                       |                         | 2020-08-01         | 2020-08-31 |                           |            |
| 1  | НИЙСЛЭЛ ӨРГӨӨ         | 105                     | 3,700.00           | 2,600.00   | -1,100.00                 | -29.73     |
| 2  | БИ ДИ СЕК             | 73                      | 950.00             | 716.00     | -234.00                   | -24.63     |
| 3  | ДАРХАН ХӨВӨН          | 87                      | 9,200.00           | 6,990.00   | -2,210.00                 | -24.02     |
| 4  | МОНГОЛ САВХИ          | 71                      | 680.00             | 550.00     | -130.00                   | -19.12     |
| 5  | АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ | 61,185                  | 1,250.00           | 1,029.00   | -221.00                   | -17.68     |
| 6  | ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ   | 3                       | 150.00             | 125.00     | -25.00                    | -16.67     |
| 7  | СОР                   | 1,789                   | 750.00             | 645.22     | -104.78                   | -13.97     |
| 8  | БУЛГАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ   | 74                      | 590.00             | 510.00     | -80.00                    | -13.56     |
| 9  | ТАНДЭМ ИНВЕСТ ББСБ    | 155,479                 | 17.90              | 15.50      | -2.40                     | -13.41     |
| 10 | ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА  | 3,881                   | 690.00             | 600.00     | -90.00                    | -13.04     |
| 11 | ОЛЛОО                 | 1                       | 69.90              | 62.90      | -7.00                     | -10.01     |
| 12 | АЙТҮҮЛС               | 44,485                  | 80.00              | 72.08      | -7.92                     | -9.90      |
| 13 | БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ  | 326                     | 31,000.00          | 28,000.00  | -3,000.00                 | -9.68      |
| 14 | СИЛИКАТ               | 27                      | 36.00              | 33.00      | -3.00                     | -8.33      |
| 15 | ШИВЭЭ ОВОО            | 1,238                   | 1,900.00           | 1,750.00   | -150.00                   | -7.89      |



## АНХНЫ ХАМТЫН ХААЛТТАЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЭГЖ ЭРХ БҮРТГЭГДЛЭЭ



Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 340 тоот тогтоол болон холбогдох дүрэм, журмыг үндэслэн гаргасан "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2020 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн А/56 тоот тушаалаар "Ард менежмент ҮЦК" ХХК-ийн үүсгэн байгуулсан "Үндэсний хувьчлалын сан" хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 50,000,000 ширхэг нэгж эрхийг Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлд бүртгэлээ.

Ийнхүү олон улсын биржүүдэд түгээмэл арилжигддаг бүтээгдэхүүн манай зах зээлд цоо шинээр нэвтэрч байгаа нь хөрөнгө оруулагчид эрсдлээ тараан байршуулж, багц хувьцаанд хөрөнгө оруулах замаар хөрөнгө оруулалтын оновчтой удирдлагаар хангагдах бодит боломж бий болж байгаагийн зэрэгцээ дотоодын зах зээлд нэн шаардагдаж буй урт хугацааны мэргэжлийн хөрөнгө оруулагчдын бааз суурь бүрэлдэж буйгаараа онцгой ач холбогдолтой юм.

## ДАВХАР БҮРТГЭЛТЭЙ ҮНЭТ ЦААСЫГ ХӨРВҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ БОЛЛОО

2018 онд Монголын хөрөнгийн зах зээлд үнэт цаасны анхны давхар бүртгэл амжилттай нэвтэрч, Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй "Эрдэнэ ресурс девелопмент корпорейшн"-ийг МХБ-д бүртгэсэн нь дотоодын хөрөнгийн зах зээлийн хөгжилд түүхэн ач холбогдолтой үйл явдал болсон бөгөөд Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг, гадаадын хөрөнгийн биржид бүртгэлтэй уул уурхайн компаниуд Монгол Улсад үнэт цаасаа гарган арилжих, эдгээр компанийн хувьцааг ард иргэд, олон нийт эзэмшиж, байгалийн баялгийн үр шимийг хүртэх боломжийг нэмэгдүүлсэн билээ.

Тус үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн ээлжит хуралдаанаар "Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад үнэт цаас гаргах, Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсад

## Үйл явдал

гаргах үнэт цаасыг бүртгэх журам-д нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Энэхүү журамд нэмэлт, өөрчлөлт оруулснаар гадаад улсын болон Монгол Улсын хөрөнгийн биржид давхар бүртгэлтэй үнэт цаасыг бирж хооронд хөрвүүлэн арилжих боломж бүрдэж байгаа бөгөөд тухайн үнэт цаасны хөрвөх чадвар сайжрах, хөрөнгө оруулагчид аль өндөр ханштай зах зээлийг сонгон арилжих боломж бүрдэх, дотоодын зах зээлд нийлүүлэлт нэмэгдэх, хөрөнгийн зах зээлд үнэт цаасыг хил дамжуулж хөрвүүлэх цоо шинэ харилцааг бий болгох зэрэг олон талын ач холбогдолтой юм.

Үүний дагуу давхар бүртгэлтэй "Эрдэнэ ресурс девелопмент корпорейшн"-ийн хувьцаа эзэмшигчид хувьцаагаа Торонтогийн хөрөнгийн биржийн гишүүн брокерийн компанид нээлгэсэн дансаараа дамжуулан тус бирж дээр арилжих боломжтой бөгөөд хөрвүүлэх ажиллагааг "ҮЦТХТ" ХХК эсвэл МХБ-ийн гишүүн брокерт хандан хийлгүүлэх юм.



## "ГЕРМЕС ЦЕНТР" ХК ХАГАС ЖИЛИЙН ЦЭВЭР АШГААС НОГДОЛ АШИГ ТАРААНА

"Гермес" ХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 8-р сарын 24-ний өдрийн №14 тоот тогтоолоор 2020 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 6.6 төгрөг буюу нийт 518.4 сая төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг болгон тараахаар болов.

Энэхүү ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг 2020 оны 9-р сарын 09-ний өдрөөр гаргах бөгөөд 2020 оны 9-р сарын 15-ны өдөр "ҮЦТХТ" ТӨХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахаар шийдвэрлэв.



## СЗХ-НЫ "ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ЖУРАМ"-ЫН ДАГУУ ТАЙЛАН ИРҮҮЛЭЭГҮЙ КОМПАНИУДЫН НЭРС

Монголын Хөрөнгийн Бирж (МХБ)-д бүртгэлтэй хувьцаат компаниуд нь “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийн 20.1.6 болон “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 10.3-р зүйлд заасны дагуу хагас жилийн санхүүгийн тайланг 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор МХБ-д хүргүүлэх үүрэгтэй бөгөөд МХБ нь үүргээ биелүүлээгүй компаниудад үнэт цаасны бүртгэлээс хасах хүртэл шат дараалсан арга хэмжээг ногдуулдаг.

МХБ нь дээрх хуулиуд болон Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ны “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам”-ын 4.11-д “... заасан мэдээллийг зохих журмын дагуу нийтэд хүргэх үүргийг биелүүлээгүй компанид Хөрөнгийн бирж зөрчил гарснаас хойш ажлын 10 өдөрт багтаан шаардлага хүргүүлэх бөгөөд зөрчлийг тогтоосон хугацаанд арилгаагүй тохиолдолд энэ талаарх мэдээллийг Хороонд хүргүүлнэ” гэж заасны дагуу 2020 оны хагас жилийн санхүүгийн тайлангаа ирүүлэх талаар 2020 оны 07 дугаар сарын 29-ний өдөр, санхүүгийн тайлан болон хагас жилийн үйл ажиллагааны тайлангаа ирүүлэх 2020 оны 08 дугаар сарын 01-ний өдөр тус тус өөрийн цахим хуудсаараа дамжуулан компаниудад мэдэгдсэн. Үүний дагуу заасан хугацаанд үүргээ биелүүлээгүй буюу хагас жилийн санхүүгийн тайлангаа ирүүлээгүй нэр бүхий хувьцаат компаниудын мэдээллийг СЗХ-нд 2020 оны 8 дугаар сарын 11-ний өдөр хүргүүлээд байна.

## МХБ-Д БҮРТГЭЛТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН АНХААРАЛД

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниуд нь Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын тухай журам”-ын 2.2, 2.4 дэх заалтын дагуу компанийн хагас жилийн үйл ажиллагааны тайлангаа 8 дугаар сарын 01-ний өдөрт багтаан МХБ-д ирүүлэхээр заасан байдаг.

Монголын хөрөнгийн биржийн зүгээс тайлан ирүүлээгүй компаниудад 8 дугаар сарын 10-ны дотор ирүүлэх хугацаа олгож байна. Иймээс хувьцаат компанийн олон нийтэд нээлттэй, ил тод байх компанийн засаглалын сайн жишгийг хангаж, үйл ажиллагааны тайлангаа заасан хугацаанд багтаан ирүүлнэ үү.

Хэрэв заасан хугацаанд хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд Монголын хөрөнгийн биржийн зүгээс зөрчлийн талаар олон нийтэд болон Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэж, СЗХ-ны “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын тухай журам”, МХБ-ийн холбогдох журмууд болон Бүртгэлийн гэрээнд заасан хариуцлагын арга хэмжээг ногдуулахыг анхаарна уу.

## Үйл явдал

### "ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС" ХК-ИЙН ОНООСОН НЭРИЙГ "ЭРДЭНЭС СОЛЮШИНС" ХК БОЛГОН ӨӨРЧИЛЛӨӨ

Монголын хөрөнгийн биржийн 3-р ангилалд бүртгэлтэй "Хар хорум пропертийс" ХК-ийн 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар тус компанийн нэрийг өөрчилж, дүрмийн шинэчилсэн найруулгыг баталсантай холбогдуулан Монголын Хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын 20120 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн А/16 тоот тушаал болон Санхүүгийн Зохицуулах Хорооны даргын 2020 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн тушаалаар "Хар хорум пропертийс" ХК-ийн оноосон нэрийг “Эрдэнэс сольюшинс” ХК болгон өөрчлөлт орууллаа.

### "БОДЬ ДААТГАЛ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Бодь Даатгал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн № 20/04 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2020 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн 11:00 цагт хуралдуулахаар болсон тул хувьцаа эзэмшигчид та бүхнийг хүрэлцэн ирэхийг урьж байна.

**Хурлын тов:** 2020 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн 11:00 цагт

**Хуралдах газар:** Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Бага тойруу, 14201, Novotel зочид буудал 4 давхрын хурлын танхимд

**Бүртгэлийн өдөр:** 2020 оны 8-р сарын 17-ны өдөр

**Хурлаар хэлэлцэх асуудал:**

- 2020 оны хагас жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг тайлагнах;
  - 2020 оны хоёрдугаар хагасын бизнес төлөвлөлтийг танилцуулах
  - Компанийн “Дүрэм”-ийн төслийг батлах;
  - Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн төсөв батлах.  
Холбоо барих утас: 70110280



## "МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ТӨХК-ИЙН 2020 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь 2020 оны эхний хагас жилд хувьцааны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар нийт 164.9 сая ширхэг хувьцааг 23.5 тэрбум төгрөгөөр, ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 5.8 мянган ширхэг үнэт цаасыг 586.9 сая төгрөгөөр, компанийн бондын анхдагч зах зээлийн арилжаагаар 50.0 мянган ширхэг үнэт цаасыг 5.0 тэрбум төгрөгөөр, хоёрдогч зах зээлийн арилжаагаар 11 ширхэг үнэт цаасыг 1.1 сая төгрөгөөр арилжиж, нийт 29.1 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа хийсэн байна.

Тайлант хугацааны голлох үйл явдлууд, өөрчлөлтүүдийг дурдвал:

- МХБ нь 2020 оны эхний хагас жилд дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас арилжааны идэвхи ихээхэн буурсан хэдий ч "Бодь даатгал" ХК-ийн 5.3 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий шинэ хувьцаа гаргалт, "ЛэндМН ББСБ" ХК-ийн 5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий компанийн өрийн хэрэгслийн арилжааг амжилттай зохион байгууллаа;
- МХБ-ийн үйл ажиллагааны үндсэн журмууд болох "Арилжааны журам"-д Үнэт цаасны төлбөр тооцооны Т+2 горим, төлбөрийн эсрэг нийлүүлэлт хийх зарчимд 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөр шилжсэнтэй холбогдуулан арилжааны хэлцлийг баталгаажуулах болон алдаатай хэлцлийг цуцлах талаар нэмэлт өөрчлөлт оруулан 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдөр СЗХ-оор батламжлуулсан;
- МХБ-ийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"-ыг шинээр боловсруулж, батлуулан, СЗХ-ны даргын 2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 146 дугаар тушаалаар батламжлуулснаар банк, санхүүгийн байгууллагуудад хөрөнгийн зах зээлээр дамжуулан санхүүжилт татах, иргэдэд тогтмол хугацаат хүүгийн орлого бүхий эрсдэл харьцангуй багатай хөрөнгө оруулалтын шинэ бүтээгдэхүүн санал болгох боломжийг нээж, эрх зүйн орчинг бүрдүүлсэн;
- Зах зээлийн ерөнхий чиг хандлагыг тодорхойлогч "ТОП-20" индексийг болон МХБ-ийн үнэт цаасны бүртгэлийн ангиллыг шинэчиллээ.
- "Райнос Инвестмент ҮЦК" ХХК-ийг гишүүнээр элсүүлэв.

Тайлант хугацаанд байгууллагын удирдлагын болон нийт ажилтнуудын цалин хөлсний хэм хэмжээнд ямар нэг өөрчлөлт огт хийгээгүй бөгөөд холбогдох хуулийн дагуу КОВИД-19 халдварт цар тахлын үеийн татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлтөнд хамрагдаагүй болно. Үйл ажиллагааны бусад зардлын тухайд тэвчиж болох бүхий л зардлыг хэмнэж ажилласнаар зардлыг өмнөх оны мөн үеэс 20%-аар бууруулж ажилласан.

Санхүүгийн үзүүлэлтийн хувьд МХБ ТӨХК нь 2020 оны эхний хагас жилд үйл ажиллагаанаас нийт 596.9 сая

төгрөгийн орлогыг олж, 694.5 сая төгрөгийн зардал гаргаснаар 97.6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан ба МИТ цогц системийн элэгдэл, хорогдлын зардлыг хуримтлуулж тооцсоноор санхүүгийн тайланд нийт 402.5 сая төгрөгийн татварын өмнөх алдагдлыг хүлээн зөвшөөрсөн байна.

## "ДАРХАН НЭХИЙ" ХК 2020 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилалд бүртгэлтэй "Дархан Нэхий" ХК-ийн 2020 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайланг тус компанийн гүйцэтгэх захирал Б.Мягмар-Өлзий, үнэт цаасны компаниудын шинжээчид болон социал сүлжээгээр дамжуулан олон нийтэд танилцууллаа. Тайлант хугацаанд:

- Нийт хөрөнгө өмнөх оныхоос 2.4 тэрбум төгрөгөөр буюу 3.9% хувиар өсч, 63.1 тэрбум төгрөгт хүрсэн байна.
- 2019 оны хагас жилд танилцуулсан томоохон хөрөнгө оруулалтын 2 төслийг амжилттай хэрэгжүүлж байна. Grand YAK зочид буудлыг 2020-05-25-нд ашиглалтанд оруулсан. Шахмал ширний төслийн гүйцэтгэл нь 92%-д хүрсэн бөгөөд тун удахгүй ашиглалтанд оруулахаар төлөвлөж байна.
- ЕСБХБ (EBRD)-тай хамтран ISO9001:2015 ЧМТ-ны зөвлөх үйлчилгээг авч, үйлдвэрлэлийн чиглэлээр 3 охин компанид чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж байна. 2020 оны 9 сард багтаан ISO стандартыг нэвтрүүлэхээр зорин ажиллаж байна.
- Цаашид эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж ОХУ руу экспортлох бэлтгэл ажлыг хангаж 8 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн экспортлохоор үйлдвэрлэлийн ажлыг эхлүүлсэн байна.

Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн хувьд улирлын борлуулалтаас хамааралгүй шинэлэг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлдээ нэвтрүүлэхээр зорин ажиллаж байна



## “АЙ ТҮҮЛС” ХК 2020 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын хөрөнгийн биржийн 2-р ангилалд бүртгэлтэй, мэдээлэл технологийн “Ай түүлс” ХК-ийн 2020 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайланг гүйцэтгэх захирал Б.Тамир, үнэт цаасны компаниудын шинжээчид болон цахим сүлжээгээр дамжуулан олон нийтэд танилцууллаа. Тайлант хугацаанд:

- “Ай түүлс” ХК-ийн нийт борлуулалтын орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27.5 хувиар өсч, 1.4 тэрбум төгрөгт хүрсэн бол цэвэр ашгийн хэмжээ 18 хувь буурч 35.5 сая төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна. Үүнээс дата төвийн үйл ажиллагаанаас 858.9 сая төгрөгийн орлого олж, 142.9 сая төгрөгийн цэвэр ашиг олсон байна.
  - “Айтүүлс” ХК болон “Фибо Глобал” ХХК хамтран “ICS MEET” гэх шинэ бүтээгдэхүүний хөгжүүлэлтийн ажлыг хийж, зах зээлд гаргахад бэлэн болоод байна. Тус аппликейшн нь онлайнаар нэгэн зэрэг 200 - 300 хүн холбогдож видео болон дуун уулзалтийг хийх боломжтой үндэсний хэмжээний анхдагч онлайн хурлын аппликейшн юм.
- Дархан хотод байрлах дэд бүтэц нь бүрэн шийдэгдсэн, ашиглалтад бүрэн орсон “Айтүүлс” ХК-ийн эзэмшилд буй барилга байгууламжид 2020 оны 3-р улиралд “Модуляр дата төв” ашиглалтад орохоор төлөвлөгдөн, ажиллаж байна.

## “УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Улсын Их Дэлгүүр” (УИД) ХК-ийн барилгад 2020 оны 6 дугаар сарын 7-ны өдөр гал гарч барилгын зарим хэсэг шатсантай холбогдуулан Цагдаагийн ерөнхий газраас шалгалт, мөрдлөг хийсэн бөгөөд шинжээчдийн дүгнэлт гарсан байна.

Дүгнэлтээр “Тус барилга дээр дээврийн ажил хийж байсан ‘Ай Ти Эн’ ХХК-ийн ажилчид хар цаасыг халааж, хайлуулан наах ажил хийх явцдаа гал алдаж гал түймэр гарахад хүргэсэн” гэж тогтоосон байна. Уг хэрэгт Цагдаагийн Ерөнхий газрын Мөрдөн байцаах алба мөрдөн шалгах ажлыг үргэлжлүүлэн явуулж байгаа бөгөөд УИД ХК болон түрээслэгч нарын хохирлын хэмжээг тогтоохоор ажиллаж байгаа аж.

Галын аюулын улмаас УИД ХК-д ихээхэн хэмжээний хохирол учирсан бөгөөд энэхүү хохирлыг дотоод хүчин чадлаараа барагдуулан даван туулах боломж бололцоо хомс учраас “Номин Холдинг” ХХК болон түүний хамаарал бүхий компаниудаас ажиллах хүч, санхүүгийн туслалцаа авсны үр дүнд 2020 оны 7 дугаар сарын 3-ны өдрөөс тус дэлгүүрийн 1 болон 2 давхрын засварын ажлыг гүйцэтгэн хэвийн ажиллагаанд оруулсан байна.

Түүнчлэн, УИД ХК нь үл хөдлөх хөрөнгийн даатгал, тус дэлгүүрт үйл ажиллагаа явуулж байсан түрээслэгч нар нь гэрээнд заасны дагуу бараа материалын даатгалд хамрагдсан болохыг УИД ХК-ийн зүгээс мэдэгдсэн байна.

## “ТҮМЭН ШУВУУТ” ХК 2020 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын Хөрөнгийн Бирж (МХБ)-ийн 1-р ангилалд бүртгэлтэй “Түмэн шувуут” ХК-ийн 2020 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайланг гүйцэтгэх захирал Ж.Болд үнэт цаасны компаниудын шинжээчид болон цахим сүлжээгээр дамжуулан олон нийтэд танилцууллаа. Тайлант хугацаанд дараах үр дүнд хүрчээ. Үүнд:

- Бүгд найрамдах Болгар улсын “Dion Engineering” Ltd –ийн бүрэн автомат, иж бүрэн, Европ стандарт хангасан тоног төхөөрөмжийг угсарч шингэн өндөгний үйлдвэрийг ашиглалтанд оруулав.
- Нийт 33.5 сая ширхэг өндөг үйлдвэрлэсэн нь өмнөх оны эхний хагас жилийн үзүүлэлтээс 2 сая ширхгээр буюу 6 хувиар өссөн байна.
- 11.7 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж, 2.0 тэрбум төгрөг буюу нэгж хувьцаанд 10.1 төгрөг ногдох ашигтай ажилласан байна.
- СХД-ийн 21-р хороо, Их булаг дахь шувууны шинэ аж ахуй нь анхны 40,000 дэгдээхийгээ хүлээн авч үйл ажиллагаагаа эхлүүлсэн байна.
- Увс аймагт усалгаатай тариалангийн талбайд 864 га-д улаан буудай, 392 га -д царгас, 216 га-д овъёос тариалав.

Сангасны органик бордооны үйлдвэрийг ашиглалтанд оруулж зөвхөн сангас болон модны үртсээр хийсэн 100 хувь органик бордоог зах зээлд нийлүүлж эхэллээ.

## “МОНГОЛ БАЗАЛТ” ХК 2020 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын хөрөнгийн биржийн 2-р ангилалд бүртгэлтэй “Монгол Базалт” ХК-ийн 2020 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайланг гүйцэтгэх захирал Б.Энхгэрэл үнэт цаасны компаниудын шинжээчид болон цахим сүлжээгээр дамжуулан олон нийтэд танилцууллаа. Тайлант хугацаанд:

Борлуулалтын орлого 1.45 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 333 сая төгрөг буюу 29.8%-иар өссөн боловч ашгийн хэмжээ буурч 19.4 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан үзүүлэлттэй байна.

Түүнчлэн, энэ онд дулаан солилцуурын зуухны угсралтын ажлыг дуусгаж, нэгдсэн камерын системийг суурилуулсан байна. Мөн амины орон сууцанд зориулсан М-50 маркын хямд чанартай бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлж эхэлснээс гадна хөдөө аж ахуйд зориулан усны хэрэглээг 80 хувь хэмнэн ургалтыг 22 хувь нэмэгдүүлдэг гидропоник хөрсийг үйлдвэрлэн БНСУ-ын харилцагчид 600 боодлыг нийлүүлсэн байна.



## "МАНДАЛ ДААТГАЛ" ХК 2020 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилалд бүртгэлтэй "Мандал Даатгал" ХК-ийн 2020 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайланг Хөрөнгө оруулалт хариуцсан захирал Г.Ганзориг үнэт цаасны компаниудын шинжээчид болон цахим сүлжээгээр дамжуулан олон нийтэд танилцууллаа. Тайлант хугацаанд:

- "Мандал Даатгал" ХК-ийн хураамжийн орлого 20.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 13 хувиар өссөн боловч нөхөн төлбөрийн зардал 45 хувь өссөнтэй холбоотойгоор цэвэр ашгийн хэмжээ буурч 2.3 тэрбум төгрөг болсон байна.

Ковид даатгал гэсэн шинэ бүтээгдэхүүн гаргасан бөгөөд 82,000 харилцагчийг үнэ төлбөргүй даатгаснаас гадна гар утасны дэлгэцийн даатгалыг зах зээлд нэвтрүүлээд байна. "Мандал Даатгал" ХК-ийн нийт хөрөнгө 51.9 тэрбум төгрөгт хүрсэн нь дотоодын даатгалын зах зээлд хөрөнгийн хэмжээгээрээ тэргүүлж байгаагаас гадна нийт хураамжийн орлого болон цэвэр ашгийн хэмжээгээр салбарын компаниудыг тэргүүлж байна.

## "БОДЬ ДААТГАЛ" ХК 2020 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилалд бүртгэлтэй "Бодь Даатгал" ХК-ийн 2020 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайланг Хөрөнгө оруулалт хариуцсан захирал Г.Билгүүн үнэт цаасны компаниудын шинжээчид болон цахим сүлжээгээр дамжуулан олон нийтэд танилцууллаа. Тайлант хугацаанд:

- "Бодь Даатгал" ХК-ийн цэвэр хураамжийн орлого 7.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 5.3 хувиар өссөн боловч нөхөн төлбөр болон үйл ажиллагааны зардал өссөнтэй холбоотойгоор цэвэр ашгийн хэмжээ буурч 765 сая төгрөг болсон байна.

Компанийн борлуулалтын сувгийг нэмэгдүүлж, <https://bodi-insurance.com/> цахим хуудсаар дамжуулан өндөр эрэлттэй 7 төрлийн даатгалын бүтээгдэхүүнийг санал болгож эхлээд байна.

Цаашид технологийн шинэчлэлтийг өргөжүүлж, АХА олон улсын эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг иргэдэд санал болгохоос гадна "Эрхэм", "Шийдэл" зэрэг шинэ бүтээгдэхүүнүүдийг зах зээлд нэвтрүүлэхээр болсон байна.

"Бодь Даатгал" ХК нь анхны цахим даатгалын үйлчилгээ болон олон улсын эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг зах зээлд нэвтрүүлсэн бөгөөд 2020 оны жилийн эцэст ашгийн хэмжээг 31.5 хувиар өсгөж, 2.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар төлөвлөж байгаа тухай мэдэгдлээ.

## "ДАРХАН НЭХИЙ" ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ НЭЭЛЭЭ

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2020 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанаар "Дархан нэхий" ХК-ийн хүсэлтийн дагуу тус компанийн хувьцааг 1000 хуваах замаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэнтэй холбогдуулан Улсын байцаагчийн 2020 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 96 тоот албан шаардлагаар хувьцаа хуваахтай холбоотой үйл ажиллагаа бүрэн хийгдэж дуусах хүртэлх хугацаанд тус компанийн үнэт цаасны арилжааг түр зогсоосон билээ.

"Дархан нэхий" компанийн хувьцааг хуваахтай холбоотой үйл ажиллагааг хийж дууссаныг тул Санхүүгийн зохицуулах хорооны Улсын байцаагчийн 99 тоот албан шаардлагын дагуу үнэт цаасны арилжааг 2020 оны 8 дугаар сарын 06-ны өдрөөс нээлээ.

## "ТАЛХ ЧИХЭР" ХК 2020 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэлтэй "Талх чихэр" ХК нь 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг Дотоод аудитор С.Дүгэр, Хуулийн зөвлөх И.Өлзийбаяр, Маркетинг бизнес хөгжүүлэлтийн газрын ахлах менежер Н.Намируун нар үнэт цаасны компаниудын шинжээчид болон цахим сүлжээгээр дамжуулан олон нийтэд танилцууллаа.

Тайлант хугацаанд:

- "Талх чихэр" ХК-ийн борлуулалтын орлого 2019 оны мөн үеэс 3.5 тэрбум төгрөгөөр өсч 28.8 тэрбум төгрөг болсон бол цэвэр ашиг 8.9 хувь өсч 818.2 сая төгрөгт хүрсэн байна.
- Хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад зориулан цахим худалдаа хийх боломж бүхий платформын хөгжүүлэлтийг эхлүүлэн ажиллаж байна.
- Монголчуудын өв уламжлал цагаан идээ болох шар тос, өрөм цөцгий, бурамтай шанз бүхий 3 төрлийн нарийн боов үйлдвэрлэн хэрэглэгчиддээ танилцуулаад байна.
- Нийгмийн хариуцлагын хүрээнд "Дархлаа дэмжих хөтөлбөр" мөн "Хямралыг хамтдаа давцгаа" хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлсэн.
- Хаан Брэндийн бургер, хотдогны талхыг зах зээлд амжилттай нэвтрүүлсэн.

"Талх Чихэр" ХК энэ ондоо багтаан бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн шинэ бодлого баримталж дэлхийн стандартад нийцсэн бүтээгдэхүүнийг эх орондоо нутагшуулах, шинэ хэрэглээний соёл бий болгохоор ажиллаж байна.



## "МИК ХОЛДИНГ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Монголбанкны 2020 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн зөвшөөрлийн дагуу Худалдаа, хөгжлийн банкинд Улаанбаатар хотын банкныг нэгтгэн нийлүүлэх замаар өөрчлөн байгуулсантай холбогдуулан Улаанбаатар хотын банкны эзэмшил дэх "МИК Холдинг" ХК-ийн нийт хувьцааны 10 хувь буюу 2,070,912 ширхэг хувьцааг Худалдаа, хөгжлийн банкинд шилжүүлсэн байна.

Энэхүү өөрчлөлтийн дагуу тус компанид эзлэх Худалдаа, хөгжлийн банкны эзэмшлийн хувь 19.99 хувь болж өөрчлөгдсөн байна.

## "ГОВЬ" ХК 2020 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛАА

Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилалд бүртгэлтэй "Говь" ХК-ийн 2020 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайланг Санхүү, стратеги төлөвлөлт хариуцсан захирал Б.Өнөболд болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Нарантуяа нар 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдөр үнэт цаасны компаниудын шинжээчид болон цахим сүлжээгээр дамжуулан олон нийтэд танилцууллаа. Тайлант хугацаанд:

- Компанийн зүгээс олон улсын зах зээлд эзлэх байр суурь, цар хүрээгээ улам өргөжүүлэхэд анхааран ажиллаж байгаагийн дүнд онлайн шинэ дэлгүүрүүдийг олон улсын зах зээлд амжилттай нэвтрүүлж, Англи, Герман, Орос, Хятад, Польш, Франц хэл дээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна.
- Олон улсыг хамарсан COVID-19 цар тахлын хорио цээрийн нөлөөллөөр дэлхийн аялал жуулчлалын урсгал хумигдсантай холбоотойгоор хагас жилийн байдлаар дотоод борлуулалтын орлого 57%-иар буурч 18.8 тэрбум төгрөг болсон. Нийт борлуулалт 37.5 тэрбум төгрөг буюу 45%-иар буурсан боловч онлайн зах зээл дээр 3.0 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 15 дахин өссөн үзүүлэлт болсон байна.

## "МОНГОЛ ШУУДАН" ХК 2020 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛАА

Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилалд бүртгэлтэй "Монгол шуудан" ХК-ийн 2020 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайланг Стратеги, бизнес хөгжил хариуцсан дэд захирал Н.Хосбаяр үнэт цаасны компаниудын шинжээчид болон цахим сүлжээгээр дамжуулан олон нийтэд танилцууллаа. Тайлант хугацаанд тус компани нь шуудангийн уламжлалт нэр төрлийн бүтээгдэхүүнийг хөгжүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд голлон анхаарч ажилласан бөгөөд дараах голлох үр дүнд хүрчээ. Үүнд:

- Гараас гарт хүргэлтийн үйлчилгээг өргөжүүлж, энэ

төрлийн үйлчилгээний орлогыг 69 хувиар нэмэгдүүлэв.

- Аймаг, хот хоорондын шуудан тээвэрлэлт, логистик үйлчилгээг өргөжүүлэн, өөрийн тээвэрээр хойд, урд, зүүн чиглэлийн нийт 11 аймаг уруу тогтмол хуваарийн дагуу тээвэрлэлт хийдэг болов.
- Ковид19 цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 9 их, дээд сургуультай хамтран ажиллаж, нийт 5000 гаруй төгсөгчийн дипломыг хаягийн дагуу хүргэв. Мөн тусгай үүргийн 25 нислэгээр гадаад шуудан солилцох горимд шилжив.
- ОХУ-БНХАУ, БНХАУ-Украйн, Эстон улс уруу дамжин өнгөрөх шуудан тээвэрлэв.
- Eurogiro байгууллагатай байгуулсан хамтран ажиллах гэрээний хүрээнд БНСУ-ын шуудангаар дамжуулан улс хоорондын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэхээр болсон бөгөөд уг үйлчилгээг "Ард кредит ББСБ" ХК-тай хамтран гүйцэтгэхээр боллоо.
- 2020 оны эхний хагас жилд 7.3 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан нь өмнөх оны мөн үеэс 398.2 сая төгрөгөөр буюу 5 хувиар өссөн боловч шинээр хэрэгжүүлж байгаа транзит тээврийн үйл ажиллагаатай холбоотой үйл ажиллагааны зардал болон орон нутгийн ажилчдын цалингийн зардал нэмэгдэж, улмаар эхний хагас жилд 3 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

## "МИК ХОЛДИНГ" ХК 2020 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛАА

Монголын хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэлтэй "Мик Холдинг" ХК 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангаа Монголын хөрөнгийн бирж дээр 2020 оны 8 дугаар сарын 05-ны өдөр танилцууллаа. Тайлант хугацаанд:

- 2020 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар нийт активын хэмжээ 2019 оны мөн үетэй харьцуулахад 1.0%-иар өссөн бол олон улсыг хамарсан цар тахлын нөлөөллөөр нийгэм, эдийн засагт бий болсон нөхцөл байдал, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зорилгоор авч хэрэгжүүлж буй арга хэмжээнээс шалтгаалан компанийн цэвэр ашиг буурсан үзүүлэлттэй байна.
- "МИК Актив Хорин Хоёр ТЗК" ХХК, "МИК Актив Хорин Гурав ТЗК" ХХК нийт 2975 зээлдэгчийн орон сууцны зээлийг худалдан авч ипотекийн зээлээр баталгаажсан бонд гаргаснаар компанийн нийт багцын хэмжээ 0.7 хувь нийт активын хэмжээ 1.0 хувиар тус тус нэмэгдсэн бөгөөд оны сүүлийн хагаст 2 удаагийн хэлцэл хийхээр төлөвлөн ажиллаж байна.
- Нийт өөрийн хөрөнгийн хэмжээ нийт хөрөнгийн 6.1%, нийт зээлийн хөрөнгийн багцын хэмжээ 85.8% болон шинээр гаргасан "Өзлүн" бондын хэмжээ нийт хөрөнгийн 19.2%-ийг тус тус бүрдүүлж байна.



## “МОНОС ХҮНС” ХК АНХ УДАА ҮЙЛДВЭРИЙН БАЙРАН ДЭЭРЭЭ 2020 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын Хөрөнгийн биржийн 1-р ангилалд бүртгэлтэй "Монос Хүнс" ХК нь 2020 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа 8-р сарын 07-ны өдөр Эрүүл мэндийн шингэн хүнсний үйлдвэрийн байрандаа танилцуулсан бөгөөд тайлангийн хуралд оролцохоор ирсэн зочид үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцсанаараа онцлог үйл явдал боллоо.

"Монос Хүнс" ХК нь 2019 онд олон нийтээс татан төвлөрүүлсэн 8.5 тэрбум төгрөгийн хөрөнгөөр олон улсын GMP стандарт хангасан, 1772 м<sup>2</sup> талбай бүхий эрүүл мэндийн шингэн хүнсний үйлдвэрийг ашиглалтад орууллаа. Энэ оны эхний хагас жилийн байдлаар борлуултын орлого 5.4 тэрбум төгрөгт хүрсэн бол цэвэр ашиг өмнөх оны мөн үеэс 18 хувиар өсч 400 сая төгрөг болсон байна.

Тус үйлдвэрийг шинээр ашиглалтанд оруулснаар Экос эрүүл мэндийн усны савлагааг шинэчлэн Оргилуун зөөлөн усаар төрлөө нэмснээс гадна Vitos шот савлагаатай 7 төрлийн эрүүл мэндийн бэлдмэл, 5 нэр төрлийн Craft tea шинээр үйлдвэрлэх бэлтгэл ажлыг эхлүүлээд байна. Харин хуурай хүнсний үйлдвэртээ Тугал брэндийн шахмал аарцан үрэл, Tastea брэндийн цагаан гаатай уусдаг цайг зах зээлд нэвтрүүлсэн байна.

## "МАХ ИМПЕКС" ХК 2020 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилалд бүртгэлтэй "Мах импекс" ХК 2020 оны эхний хагас жилийн санхүү болон үйл ажиллагааны тайлангаа үнэт цаасны компаниудын шинжээчид болон цахим сүлжээгээр дамжуулан олон нийтэд танилцууллаа.

- Тус компани эхний хагас жилд 14.5 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, 293.3 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Дэлхий нийтийг хамарсан хөл хорионоос шалтгаалан махан бүтээгдэхүүн, хонь, адууны махны үйлдвэрлэл тодорхой хувиар буурч махны экспорт хэсэг хугацаанд тасалдсан, мөн дотоодын зах зээл дэх махны борлуулалтын ашиг, түрээсийн орлого буурсан зэргээс шалтгаалан төлөвлөгөөт цэвэр ашиг 2.5 дахин буурсан байна.

- Хөргөлтийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлын хүрээнд 16 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аммиакийн болон усны насосуудыг худалдан авч суурилуулсан, 200 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ОХУ-аас хөргөлтийн шингэн болон аммиакийг импортлон оруулж ирсэн байна.

- Цахилгаан цех, дахин дамжуулах подстанцын дээврийг шинэчлэх ажилд 72 сая төгрөг зарцуулсан. Мах ангиан боловсруулах үйл ажиллагаанд зориулан БНХАУ-ын Hebei Xiaojin компаниас 50.3 сая төгрөгийн махны машин худалдан авсан байна.

Цаашид экспортыг нэмэгдүүлэхийн тулд төр засгийн байгууллагуудтай хамтран ажиллах, махны жижиглэн

## Үйл явдал

худалдаа уруу борлуулалтаа чиглүүлэх, онлайн худалдааг эхлүүлэх, нэр төрлийг нэмэгдүүлэх зэрэг ажлуудыг хийж хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

## "ТАВАНТОЛГОЙ" ХК 2020 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын Хөрөнгийн Бирж (МХБ)-ийн 1-р ангилалд бүртгэлтэй "Тавантолгой" ХК 2020 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайланг үйлдвэрлэл эрхэлсэн дэд захирал Ж.Доржсүрэн, эдийн засагч Ч.Төрмандах нар 2020 оны 8 дугаар сарын 17-ны өдөр танилцууллаа.

Тайлант хугацаанд:

- Дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас хилийн хориг, онцгой нөхцлөөр хил нэвтэрч байгаатай холбоотойгоор нүүрсний экспорт буураад байна. Компани 2020 оны эхний хагас жилд 1.1 сая тонн нүүрс олборлосноос 831.7 мянган тонныг борлуулж, 91.6 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 25.9 хувиар буурсан үзүүлэлт болжээ. Мөн уул техникийн нөхцлөөс шалтгаалан бүтээгдэхүүний өртөг нэмэгдсэнтэй холбоотойгоор цэвэр ашгийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс буурч 3.9 тэрбум төгрөгт хүрчээ.
- "Тавантолгой" ХК нь 2019 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 821 төгрөг буюу нийт 43.2 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулсан бөгөөд сүүлийн 15 жилд нийт 519.3 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчиддээ хуваарилсан байна.

Цаашид борлуултын хэмжээг нэмэгдүүлэх, олборлолтын өртгийг бууруулах, тээвэрлэлтийн зардлыг бууруулахаар ажиллаж байна.

## "ГОВЬ" ХК 2019 ОНЫ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ТАЙЛАН ИРҮҮЛЛЭЭ

"Говь" ХК нь компанийн сайн засаглалыг хэрэгжилтийн сайжруулах зорилгоор компанийн засаглалын өөрийн үнэлгээний тайланг 3 дахь жилдээ гарган ирүүлсэн байна.

Тус компани нь өнгөрсөн онуудад засаглалын өөрийн үнэлгээг гаргахдаа бичиг баримтын боловсруулалтад илүү ач холбогдол өгч дүгнэсэн бол энэ жил бичиг баримтын хэрэгжилтэд анхаарч дүгнэсэн байна. Цаашид сайн засаглалаараа манлайлах зорилтыг тавин үйл ажиллагаанд мөрдлөг болгох баримт бичгийн боловсруулалтыг сайжруулж, түүний хэрэгжилт дээр илүү анхаарч тасралтгүй сайжруулалт хийж ажиллахаар болсон байна.

Манай улсын компани бүр компанийн засаглалын зарчмуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгосноор компанийн тогтвортой хөгжил, хөрөнгө оруулалтын таатай нөхцөлийг бүрдүүлэхээс гадна эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангахад чухал хувь нэмэр оруулах билээ.



## “АПУ” ХК ХАГАС ЖИЛИЙН ЦЭВЭР АШГААС НОГДОЛ АШИГ ХУВААРИЛНА

“АПУ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 08-р сарын 13-ны өдрийн хурлын 20/14 тоот тогтоолоор компанийн хагас жилийн санхүүгийн үр дүнг харгалзан нэгж хувьцаанд 37.5 (гучин долоон төгрөг тавин мөнгө) төгрөг, нийт 39.9 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гарах бүртгэлийн өдрийг эчнээ санал хураалтын хэлбэрээр зохион байгуулагдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын бүртгэлийн өдрөөр тогтоох бөгөөд 2021 оны 2 дугаар сарын 10-ны өдөрт багтаан тараахаар болсон байна.

## “АПУ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛ БОЛНО

“АПУ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн 20/15 тоот тогтоолоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг эчнээ санал хураалтын хэлбэрээр зохион байгуулахаар болсон байна.

**Саналын хуудас хүлээн авах хугацаа:** 2020.08.21-ний өдрөөс 2020.10.02-ны өдрийн 16.00 цаг хүртэл

**Саналын хуудас хүлээн авах газар:** “БиДиСек ҮЦК” ХК эсвэл хувьцаа эзэмшигчийн харилцдаг үнэт цаасны компани

**Бүртгэлийн өдөр:** 2020 оны 9 дүгээр сарын 02-ны өдөр

**Хурлаар хэлэлцэх асуудлууд:**

1. “АПУ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгох;

2. “АПУ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд (кумулятив аргаар сонгогдох 9 гишүүн)-ийг сонгох

**Хурал зохион байгуулах коммиссын бүрэлдэхүүн:** Хурал зохион байгуулах коммиссын Дарга: Ч.Ариунсан, Гишүүн: Э.Солонго, Б.Мягмар

## “ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИЙН” 2020 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын хөрөнгийн биржийн 3-р ангилалд бүртгэлтэй “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн”-ийн 2020 оны эхний хагас жилийн санхүү болон үйл ажиллагааны тайланг Хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд ерөнхийлөгч А.Билгүүн үнэт цаасны компаниудын шинжээчид болон цахим сүлжээгээр дамжуулан олон нийтэд танилцууллаа.

Тайланг хугацаанд:

- Баян Хөндий Алтны Төслийн хөгжүүлэлт болон Хөндий Алтны Дүүргийн өндөр агуулга бүхий нөөцийг тэлэх гол зорилтуудын хүрээнд үр дүнтэй ажиллаж зорилтот талбаруудад газрын дөт гүнд, өндөр агуулгатай хүдэржилтийг илрүүлсэн байна.
- Нарийвчилсан ТЭЗҮ-г амжилттай батлуулсан бөгөөд хөрөнгө оруулалт болон үйл ажиллагааны өртөг бага, богино хугацаанд буюу хоёр жилийн дотор эргэн

## Үйл явдал

төлөгдөх, ирээдүйд тэлэх боломж бүхий Баян Хөндий төслийн олборлолтыг 2022 онд эхлүүлэхээр төлөвлөөд байна.

- 2020 оны 3-р улиралд БОНБНУ-ний олон нийтийн хэлэлцүүлгийг хийж, хууль журмын дагуу батлуулахаар Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлсэн байна.
- Уурхайн бүтээн байгуулалтад шаардлагатай гол зөвшөөрлүүд, ил уурхай болон холбогдох дэд бүтцийг барихад шаардагдах 100 га талбайн зөвшөөрлийг авсан.
- Татварын тогтворжуулах гэрчилгээний өргөдөл тодорхой нөхцөлтэйгөөр зөвшөөрөгдсөн бөгөөд үүний хүрээнд Монгол Улсын өнөөгийн татварын хувь хэмжээ 9 жилийн турш тогтвортойгоор үйлчилнэ.
- Хаалттай хүрээнд 20 сая кан.долларын санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлсэн бөгөөд үүний 15 сая долларын санхүүжилтийг Канадын алтны

## “ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИЙН”-ЭЭС ИРҮҮЛСЭН МЭДЭЭЛЭЛ

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Хөндий Алтны Дүүргийн өндөр агуулга бүхий нөөцийг нэмэгдүүлэх, саяхан танилцуулсан нарийвчилсан ТЭЗҮ-ийн үр дүнгүүдийг үргэлжлүүлэн Баян Хөндийн бүтээн байгуулалтын ажлуудыг эхлүүлэхэд зарцуулахаар хаалттай хүрээнд стратегийн хөрөнгө оруулалт бүхий \$20 сая кан.долларыг амжилттай татан төвлөрүүлсэн байна. 2020 оны 7 сарын 23-нд танилцуулсан хаалттай хөрөнгө оруулалтын хүрээнд тус бүрийг \$0.45 кан.доллараар үнэлсэн 33,333,333

нэгж захиалгын баримтыг Канад улсын томоохон хөрөнгө оруулагч ноён Эрик Спроттын эзэмшдэг 2176423 Ontario Ltd хуулийн этгээд худалдан авч, түүнтэй зэрэгцэн тус бүрийг \$0.45 кан.доллараар үнэлсэн 11,111,108 ширхэг үнэт

цаасны нэгжийг амжилттай арилжаалж хөрөнгө оруулалтыг хаасан байна.

## “ЛЭНДМН ББСБ” ХК 2020 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын Хөрөнгийн Бирж (МХБ)-ийн 1-р ангилалд бүртгэлтэй “ЛэндМН ББСБ” ХК 2020 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа танилцууллаа. Тайланг хугацаанд системийн шинэчлэлд анхаарч ажилласан бөгөөд дараах голлох үр дүнд хүрсэн байна. Үүнд:

- “ЛэндМН Бонд” нээлттэй өрийн хэрэгслийг амжилттай гаргаж, жилийн 17 хувийн хүүтэй, нийт 5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлсэн байна.
  - Системийн хөгжүүлэлт хийж, зээлийг хэсэгчлэн төлөх болон бонус оноогоор шимтгэлийн хэмжээг бууруулах боломжийг бүрдүүлж байна.
- Цэвэр ашгийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12 хувиар өсч, 2.8 тэрбум төгрөгт хүрчээ.



## "БОДЬ ДААТГАЛ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН АНХААРАЛД

"Бодь Даатгал" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн № 20/04 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2020 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн 11:00 цагт хуралдуулахаар болсон тул хувьцаа эзэмшигчид та бүхнийг хүрэлцэн ирэхийг урьж байна.

**Хурлын тов:** 2020 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн 11:00 цагт

**Хуралдах газар:** Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Бага тойруу, 14201, Novotel зочид буудал 4 давхрын хурлын танхимд

**Бүртгэлийн өдөр:** 2020 оны 8-р сарын 17-ны өдөр

**Хурлаар хэлэлцэх асуудал:**

- 2020 оны хагас жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг тайлагнах;
- 2020 оны хоёрдугаар хагасын бизнес төлөвлөлтийг танилцуулах
- Компанийн "Дүрэм"-ийн төслийг батлах;

## "ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН"-ЭЭС ИРҮҮЛСЭН МЭДЭЭЛЭЛ

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD | MSE:ERDN) нь Хөндий Алтны дүүрэг дахь тусгай зөвшөөрлийн талбайд томоохон өрөмдлөгийн хөтөлбөр эхлүүлээ.

"Баян Хөндийд хийгдэж эхэлсэн энэхүү хөтөлбөрөөр нийт 18,000 метр өрөмдлөгийг он дуусахаас өмнө гүйцэтгэхээр төлөвлөсөн бөгөөд ирэх долоо хоногос Хар Морь талбайд хоёрдугаар өрөмдлөгийн багыг ажиллуулж эхлэхээр болсон байна. Энэхүү хөтөлбөр нь дүүргийн шинэ талбайнуудыг шалгах, одоогийн ордуудтай зэрэгцээ орших талбайд нөөц нэмэгдүүлэх, одоогийн нөөцийн

талбайг бататгах, цаашид Баян Хөндийн үйлдвэрлэлийн нөөцийг нэмэгдүүлэх зорилго тавиад байна.



**ИРГЭН ТА БАЙГАЛИЙН БАЯЛГААС  
ХУВААРИЛАГДАЖ БУЙ НОГДОЛ АШГААРАА  
ДОТООДЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙЖ, ХУРИМТЛАЛТАЙ  
ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ИРГЭН БОЛОХ  
БОЛОМЖТОЙ**



[WWW.MSE.MN](http://WWW.MSE.MN)

# МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ



Монгол Улс, Улаанбаатар  
хот 15160

Сүхбаатарын талбай-3

Монголын Хөрөнгийн Бирж



+976 11-313747-2129



+976 11-325170



Info@mse.mn



WWW.MSE.MN